

УВС АЙМГИЙН БӨХМӨРӨН СУМЫН
НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ
“НҮҮРСТ ХОТГОР 1-Р ДАВХАРГА” ИЛ
УУРХАЙН ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-005696

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2003821

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, Байгалийн нөөцийн
удирдлагын газрын Ахлах шинжээч

Ц.Жаргалнэмэх

Биелэлтийг тайлагнасан:

Эрчим Баян-өлгий ХК-ийн
Захирал

М.Тилеуберди

Эрчим Баян-өлгий ХК-ийн
Байгаль Орчны ажилтан

Д.Батзул

2025 он

Гарчиг

1. “Нүүрст хотгор 1-р давхарга” талбайн ерөнхий мэдээлэл-----	2
1.1. Товч танилцуулга -----	2
1.1.1. Нөөцийн мэдээлэл -----	3
1.1.2. Төслийн хүчин чадал -----	3
1.2. Физик-Газарзүй, дэд бүтэц-----	4
1.2.1. Газарзүйн байрлал-----	4
1.3. Ордын геологийн тогтоц -----	5
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний-----	7
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт -----	10
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-----	11
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт-----	14
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт-----	19
9.1 Агаарын чанарын шинжилгээ -----	19
9.2 Хөрсний шинжилгээ-----	19
9.3 Гадаргын болон гүний усны шинжилгээ -----	20
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт -----	23
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт --	27
Хавсралт -----	28

1. “Нүүрст хотгор 1-р давхарга” талбайн ерөнхий мэдээлэл

1.1. Товч танилцуулга

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст хотгорын нүүрсний ордын талбайгаас “Давхарга-1” нэртэй 29га лицензийн талбайг бүртгэлийн 211001067 тоот гэрчилгээтэй “Рысжан”ХК-д 30 жилийн хугацаатай олгож 2009 оны 04 сарын 03-ний өдрийн ГУУКХ-ийн даргын 39 тоот шийдвэрээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг 210001004 тоот гэрчилгээтэй “ЭрчимБаян-Өлгий” ХК-д шилжүүлсэн болно. “Эрчим Баян-Өлгий” ХК-ийн эзэмшиж буй MV-005696 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Нүүрст хотгор 1-р давхарга” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1700 км, Увс аймгийн төв Улаангом сумаас баруун хойш 130 км, Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос зүүн хойшоо 131 км, Бөхмөрөн сумын төвөөс зүүн хойшоо 60 км, Хотгорын нүүрсний уурхайгаас баруун тийш 7 км-ийн зайд оршдог.

Талбайн булангийн солбилцолууд		
Булангийн цэгийн дугаар	Цэгийн солбилцол	
	Өргөрөг	Уртраг
1	90° 47' 56, 21 ⁱⁱ	49°49'52, 97 ⁱⁱ
2	90°47'31, 22 ⁱⁱ	49°49'52, 97 ⁱⁱ
3	90°47'31, 22 ⁱⁱ	49°49'11,77 ⁱⁱ
4	90° 47' 56, 21 ⁱⁱ	49°49'11,77 ⁱⁱ



Зураг-1 Талбайн байршил

1.1.1. Нөөцийн мэдээлэл

Нөөцийн мэдээлэл					
№	Нөөцийн зэрэглэл	Блокийн дугаар	Давхаргын эзлэхүүн, мян.м3	Эзлэхүүн жин тн/ м3	Нүүрсний нөөц мян.тн
1	Бодит нөөц	В-1	3720.1	1.38	5133.7
2		В-2	2763.2	1.38	3813.2
3		В-3	402.5	1.38	555.5
4		В-4	636.1	1.38	877.2
Нийт дүн			7521.9		10380

1.1.2. Төслийн хүчин чадал

“Эрчим Баян-Өлгий” ХК-ийн нүүрсний уурхайн жилд 70000 тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Тус уурхайн Баян- Өлгий аймгийн төвийн Дулааны станц, Өлгий хот, Бөхмөрөн сумын оршин суугч айл өрхүүдийн нүүрсний хэрэглээг хангах зорилгоор нүүрс олборлох, борлуулах үйл ажиллагааг явуулдаг. “Эрчим Баян-Өлгий” ХК нь Ашигт малтмалын газрын Нүүрсний хэлтсээр батлуулсан 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явууллаа.

Тус компанийн үйл ажиллагаа 19 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа. Одоогийн байдлаар Техник Эдийн Засгийн Үнэлгээг 2025 онд шинээр батлуулсан.

Төсөлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт			
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг
1	DAEWOO-280	0.8-1м ³	1
2	Ачигч ZL 30	3 м ³	1
3	НІТАСНІ 210W	1.3м ³	1
4	Бульдозер	2.5 м ³	1
5	Усны тэрэг, Зил 130	5 тн	1
6	Суудлын машин	5 хүн	1
7	НІТАСНІ 330W	1,0-1,2м ³	1
8	Автосамсомал	25 тн	3
Нийт дүн			10

Ажиллах хүчний мэдээлэл		
№	Албан тушаал	Орон тоо
Инженер техникийн ажилтан		
1	Уурхайн дарга	1
2	Ерөнхий инженер, Маркшейдер	1
3	Ашиглалтын инженер	1
4	Байгаль орчны ажилтан	1
Үйлдвэрийн хэсэг		
1	Экскаваторын оператор	2
2	Автосамосвалын жолооч	2
4	Гагнуурчин, цахилгаанчин	1
5	Бульдозерын оператор, жолооч	1
6	Засварчин	1

7	Ачигчийн оператор	1
8	Үйлчлэгч	1
9	Тогооч	1
10	Манаач	1
11	Галч	1
12	Хүнд механизмын жолооч	3
Нийт дүн		16

1.2. Физик-Газарзүй, дэд бүтэц

1.2.1. Газарзүйн байрлал


Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, өндөрт өргөгдсөн уул, нуруу нам хотгор ээлжлэн тархсан газарзүйн байрлалтай

Бөхмөрөн сумын орчим эх газрын уур амьсгалтай, хур тунадас их, жилд дунджаар 123 -144 мм, үүний 85 -95 хувь нь дулааны улиралд (IY–X сар) унадаг, хамгийн их тунадас 7дугаар сард унаж жилийн нийлбэрийн 30% орчим хүрнэ. Өвөл харьцангуй хүйтэн, дунджаар 4-30 мм тунадас унадаг. Агаарын жилийн дундаж температур –3.70C хүрч 1-р сарын дундаж температур –49.60C, 7-р сарынх +38.40C хүрнэ. Агаарын температурын хамгийн их агуурс 88.00C байна.

Гүний усны түвшин нь геологийн ажлын явцад 45 метрээс доор илэрснийг тогтоосон. Тус уурхай нь 45 м хүртэл олборлолт явуулна гэж тооцоолсон.

Төсөл хэрэгжих орчмын газар нутаг нь ургамалжилтын байдлаар Евразийн хээрийн мужийн Ачит нуурын хотгорын цөлийн хээрийн тойрогт хамаарагдана. Энд Элдэв өвс-Үетэнд, Хялганат, Элдэв өвс-Улалж-Биелэг өвс-Үетэн, Агь-Хялганат, Ботуул-Агьд бүлгэм жилтэй бөгөөд *Stipa krylovii*, *Cleristogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Carex duriuscula*, *Allium bidintatum*, *Agenaria cappilaris** *Artemisia frigida* зэрэг олон төрөл зүйлийн ургамлын нөмрөгтэй.

Уурхайн нь Ачит нуурын хотгорын зүүн хойд хэсэгт Байрамын нурууны өвөрт далайн түвшинээс 2050-2100 метрийн өндөрт уулархаг бүсэд байрлах бөгөөд уулын хуурай хээрийн цайвар хүрэн хөрс зонхилон тархсанаараа онцлогтой.



Зураг-2. Хотгорын нүүрсний ордын газар доорх ус

Бөхмөрөн сум нь хойд талаараа Оросын Холбооны улс, зүүн талаараа Сагил, Түргэн урд талаараа Ховд сум баруун талаараа Баянөлгий аймгийн Ногоон нуур сумтай тус тус хиллэдэг. Аймгийн төв Улаангом сумаас 260км алслагдсан

589 айл өрхтэй 2290 хүн амтай, 3 багтай Гурван жигэртэй, Байшинт, Хар алтат. Хүн амын гол хөдөлмөр мал аж ахуй хувиараа газар тариалан эрхлэн амьдардаг. Нүүдлийн мал аж ахуйтай. Захиргаа, эмнэлэг, сургууль /8-11/, цэцэрлэг, харилцаа холбоо зэрэг улсын төсвийн байгууллагууд ажиллахаас гадна худалдаа үйлчилгээ, жижиг үйлдвэрлэл эрхэлдэг. Аймаг сумдын хооронд авто тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн сүлжээнд холбогдсон. Цаг уурын эрс тэрс уур амьсгалтай. Манай уурхай Хар алтат багт оршдог.

1.3. Ордын геологийн тогтоц

Нүүрст хотгорын ордын судлагдсан районы геологийн тогтолцоо нь янз бүрийн насны бүтэцтэй чулуулгуудаас бүрдэнэ. Энэ нь ихэвчлэн төрмөлийн үед хамаарагдах боловч, Кембрийн түрүү чулуулаг бага хэмжээтэй байдаг. Мөн дунд төрмөлийн үеийн хурдас их биш тархсан ба шинэ төрмөлийн үеийн чулуулаг газар бүр тохиолдоно. Үүнд:

Кембрийн өмнөх үеийн хурдас Түргэн, Байрамын зүүн хойд хажуугаар баруун хойш чиглэсэн 20 км өргөн хлорлог гялтгануурт, цахиулаг занар, шохойн чулуу, Нейс, кварц зэрэг чулуулгуудаас тогтсон байна.

Палеозойн үеийн хурдас нүүрсний ордноос зүүн хойш Цагаан Шивээт , Байрам түргэний уулсын гол хэсгээс Ачит нуурын хотгорын хойд зах хүртэл тархсан 200м зузаан хөрсөн чулуу, шохойн чулуу, гантиг зэргээс тогтжээ. Энэ чулуулаг нь олон янзын өнгөтэй, их уналтын өнцөг нь 70-80 хэм хүрнэ. Эдгээр чулуулаг итсилурын үед тогтжээ.

Девоны үеийн хурдас: Байрам болон Түргэний нурууны урд талаар тархсан нарийн ширхэгтэй элсэн чулуулаг дотроо үелсэн хар өнгийн цахиржсан занартайгаас гадна бага зэргийн гравелит хөрсөн чулуу орно. Үүний нийт зузаан нь 3.5км юм.

Мезовойн үед улаан өнгийн бутархай хөрсөн, элсэн чулуу хамаарагдана. Зузаан нь 200м .

Дөрөвдөгч галавын үед газрын гадаргын байдлаас болж жигд биш тархсан байна. Мөстөлт, усны нөлөөллөөс элэгдэж тогтсон хурдас уулын хормойд ил зузаан тогтож харагдана.

Гүний чулуулаг: Цолезойн үед хамаарагдана. Үүнд:

- а. Каледоны үеийн боржин
- б. Герциний үеийн диорит габбродиорит
- с. Герциний үеийн боржин гэж хуваагдана.

Герциний үеийн гүний чулуулаг ордын орчим өргөн тархсан гэж судлагдсан байна. Тус орд нь Хотгор нэртэй мульд структурын баруун захад далайн түвшинээс дээш 1880-1912 м өргөгдсөн нам өндөрлөгтэй уулсын бүсэд оршдог. Энд 2009 оноос ил аргаар олборлолт хийж эхэлсэн ба талбайн төв хэсэгт 170 х 100 м хэмжээтэй, 13 м гүнтэй уурхай бий болжээ.


Нүүрсний ордын талбайд дунд-дээд карбоны настай Улиастай формацын тунамал, галоцены настай аллювийн гаралтай сэвсгэр хурдас тус тус тархжээ. Дунд-дээд карбоны настай Улиастай формацын хурдас нь нүүрсний ордын зүүн хагаст тархсан ба голдуу конгломерат, гарвелит, том-дунд ширхэгт элсэн чулуу болон нүүрсний давхаргаас бүрэлдэн тогтоно. Нүүрсний ордын хэмжээнд Улиастай формацын хурдас нь хойшоо суналтай, зүүн тийш 20-350 уналтай байна. Тус формацын зүсэлт нь саарал өнгөтэй конгломерат-гравелитын, нүүрс агуулсан цоохор өнгөтэй элсэн чулууны, саарал өнгөтэй гравелитлэг элсэн чулууны, нүүрсний давхарга бүхий алевроэлсэн чулууны зэрэг 4 багцаас бүрдэнэ

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1. Агаарын чанар		
1	Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, үзлэг оношилгоонд хамруулах	2025 оны 1, 4 болон 9 дүгээр саруудад уурхайд ашиглагдаж байгаа техникүүдийг техникийн улсын үзлэгт хамруулсан.
2	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах	Зам усалгааг усны машинаар тогтмол хийсэн.
3	Машин механизм тоног төхөөрөмжөөс үүсэж буй дуу шуугианыг багасгах үүднээс хуучирсан тоног төхөөрөмжийг ашиглахгүй байх, засварлах, шинэчлэх	Уурхайн талбайд ашиглагдаж байгаа бүх техникийг техникийн улсын үзлэгт бүрэн хамруулсан бөгөөд энэ уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө бүх техникийг шалган урсгал засварыг бүрэн хийж гүйцэтгэн ажилд гаргасан.
2. Хөрсөн бүрхэвч		
4	Уурхайн талбайд шимт хөрсийг тухайн талбайд нөхөн сэргээхэд буцааж ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгалах	Тайлант онд 16950м ³ хөрс хуулалтын ажил хийгдсэн бөгөөд шимт хөрсийг шимт хөрсний овоолгод буулган хадгалсан.
5	Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байх	Уурхайн талбай дотор ашиглагддаг зам дээр тэмдэг тэмдэглэгээг тогтмол тавин ажилласан бөгөөд шинээр зөвшөөрөлгүй зам гаргахгүйгээр тогтмол хяналт тавьсан.
6	Хөрсний шинжилгээний дүнгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж гадаад овоолгын талбайд хаях	Хөрсний чанарын шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүнг хяналт шинжилгээний хэсэгт оруулав.
7	Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх	Ариутгал халдваргүйжуулалтын ажлыг 2 удаа хийж гүйцэтгэлээ.
8	Мод бут тарьж зүлэгжүүлэх, тарьсан модоо арчлах	Бөхмөрөн сумын төвийн зам дугаа 6х100 хэмжээтэй талбайд нийт 110 ш мод, 90ш модыг лицензийн талбайд тарьсан модны талбайд нөхөн тарилт болгон хийсэн ба модны усалгаа арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг нөхөн сэргээлтийн хэсгээс харна уу.
3. Гадаргын ба газрын доорхи усны нөөц		
9	Төрийн байгууллагаар ус ашиглах дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2025 оны 03 сарын 06-ны Е-2025-000234 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан, Увс аймгийн БОГ-ын 2025 оны 04 сарын 10-ны өдрийн А/12 тоот ус ашиглах зөвшөөрөл олгон, 2025 оны 04 сарын 10-ны өдөр дугаар 01 ус ашиглах гэрээ байгуулсан.
10	Усны чанарын шинжилгээг тогтмол хийлгэх	Усны чанарын шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийлгэсэн. Шинжилгээний үр дүнг хяналт шинжилгээний хэсэгт оруулав.

11	Ус ашигласны төлбөрийг төлөх	Ус ашигласаны төлбөрийг цаг тухай бүрт нь төлсөн. Төлбөрийн баримтыг хавсаргав.
----	------------------------------	---

Уурхайн талбайд шимт хөрсийг тухайн талбайг нөхөн сэргээхэд буцааж ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгалах: 2025 онд уурхайн нүүрсний нөөц 55 м хүртэл гүнд үргэлжлэн тогтсон бөгөөд одоогоор уурхайн ухашийн гүн бүрэн нөөцөө авах хэмжээнд хүрээгүй байгаа тул уурхайн олборлолтын талбайн хэсэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг одоогоор төлөвлөөгүй тул шинээр газар хөндөлтийн ажил явагдсан тохиолдолд шимт хөрсийг шимт хөрсний овоолгод буулган хадгалж байна. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 16950м³ хөрс хуулан овоолго үүсгэн хадгалсан болно.



Зураг -3. Хөрс хуулалтын ажил болон овоолгод буулгаж буй байдал

Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах:

Уурхайн орчмын тоосжилтыг дарах зорилгоор замын усалгааг усны машинаар тогтмол хийлээ.



Зураг -4. Уурхайн замын тоосжилт дарах усалгаа хийж байгаа байдал

Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байх:

Уурхайн доторх замын тэмдэг тэмдэглэгээг тогтмол засварлан сайжруулж шаардлагатай цэгүүдэд байрлуулсан. Мөн уурхайн талбайд нэвтэрсэн тээврийн жолооч нарт тогтмол заавар зөвөлгөөг танилцуулан ажиллаа.



Зураг -5. Уурхайн доторх замын тэмдэг тэмдэглэгээ

Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх:

Уурхайн үйл ажиллагааны явцад халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэн 5,7 сард нийт 2 удаа уурхайн хогийн цэг болон бие засах газарт ариутгалын ажлыг хийсэн. Ариутгалд 2,5 кг хлорын шохой буюу ариутгалын бодис ашигласан.

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Мод тарих	Бөхмөрөн сумын төвийн зам дагуу 110 ш улиас мод тарин, хашаалж хамгаалав.

Нүүрсний гүн 53 метрээс дээш байна. Карьерийн гүн 18 метрт хүрч байна . Доошоогоо 35 м нүүрс байна. Тийм учраас техникийн болон, биологийн нөхөн сэргээлт хийх ажил төлөвлөгдөхгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, Увсын 2 живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд уурхайн үйл ажиллагаа явагддаггүй хэсэгт жил бүр мод тарисан бөгөөд тарьсан моддын усалгаа арчилгааг тогтмол хийж ирсэн. Тайлант онд 110 ш улиасыг Бөхмөрөн сумын төвийн зам дагуу тарьж, 6х100м харьцаатай төмөр хамгаалалтын хашаа барьсан. Мөн 90 ш улиасыг уурхайн талбайд нөхөн тарилтаар тарьсан.



Зураг-6. Өмнөх онуудад тарьсан моддын усалгаа арчилгаа болон тайлант онд шинээр мод тарьсан талбайн хашаа барих ажил болон мод тарих үеийн зураг

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Нарангийн булаг тохижуулах	Шинэ усны гар худгийг сэргээж, ажиллагаанд оруулсан.
2	Зэрлэг ан амьтны бэлчээр газар хужир шүү, өвс тавьж өгөх	2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Бөхмөрөн сумын Цахирын ам хэмээх газар Аргалын нутагладаг байршилд биотехникийн арга хэмжээ авч ажилласан.

Шинэ усны гар худаг тохижуулах ажил: Шинэ усны хөндийд байрлах орон нутгийн малчдын мал усалгаа болон ундны усны хэрэгцээгээ хангадаг байсан гар худаг борооны үерийн улмаас дарагдан ашиглах боломжгүй болсон бөгөөд орон нутгийн хүсэлтээр энэхүү худгийг сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн. Дарагдсан гар худгийн доторх үерийн усаар зөөвөрлөгдөн дүүргэгдсэн материалыг ухаж гарган ундрагыг сэргээсэн бөгөөд худгийн дотор талд кольцо суулган хананы нуруалтаас сэргийлсэн.



Зураг - 7. Үерийн усанд дарагдсан худгийг сэргээж байгаа ажлын зураг

Зэрлэг ан амьтны бэлчээр газар хужир шүү, өвс тавьж өгөх: Бөхмөрөн сумын Цахирын ам хэмээх газар нь Аргалын нутагладаг байршил бөгөөд төлөвлөгөөний дагуу 2025 оны 2 дугаар сарын 03-ны өдөр Бөхмөрөн сумын БОТХТ-тай хамтран биотехникийн арга хэмжээ авч ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд 1 тн давс, 20 боодол өвсийг тараан байршуулсан.



Зураг - 8. Бөхмөрөн сумын Цахирын аманд хийсэн биотехникийн арга хэмжээний зураг

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Хөшөө чулуу, хиргисүүрүүдийн хашааг засварлах	Хашаа хамгаалалтыг цагаан өнгийн будагаар будан, засвар үйлчилгээ хийсэн

Манай уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд 2 ширхэг хөшөө чулуу, 6 хиргисүүрүүд байдаг. Энд байгаа хөшөө чулуу хиргисүүрүүдийг хашаалан хамгаалалтад авсан. 2011 оны 10 дугаар сарын 25-нд Улаанбаатараас Ш.У.А-ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, Соёлын өвийн хяналтын улсын байцаагч, доктор дээд профессор Ц.Төрбатаар судалгаа хийлгэж, улсын тооллогод бүртгүүлсэн болно. 2021 онд уурхайн урьд талын ирмэгт тэлэлт хийхийн тулд $x=5522450$ $y=341515$ координаттай хиргисүүрүүдийг ШУА-ийн Археологийн хүрээлэнд хүсэлт гаргаж гэрээ хийсэн тул аврах малталт хийлгэсэн.

Хөшөө чулуу хиргисүүрийн хашаа хамгаалалтыг будаж, сэргээх ажлыг жил бүр хийж гүйцэтгэдэг бөгөөд тул тайлант онд бүрэн бүтэн байдлыг тогтмол шалган, эдвэрсэн хэсгийг засах, хашаа хамгаалалтыг будаж сэргээх ажлыг хийлээ.



Зураг -9. Хөшөө чулуу хиргисүүрийн хамгаалтанд авсан байдал

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагааны явцад технологийн үйл ажиллагаанаас үүдэн ус нэвчих, гал түймэр гарах зэрэг эрсдэл гарч болзошгүй тул осол, эрсдлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралттай арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж, ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт явуулан, үйл ажиллагаанд дотоод хяналт тавин ажиллаа.

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Ажилчдыг ажлын хувцасаар хангах	“Жанат”ХХК-ны захирлаан 2024 оны 01 сарын 02-ны өдрийн дугаар 06 тушаалын дагуу тайлант оны 4 дүгээр сарын 11 болон 22-ны өдөр тус бүр ажилчдад ажлын хувцас олгон бүртгэл хөтөлсөн.
2	Ажилчдыг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах. Тогтмол олгох	Ажилчдад шаардлагатай хөдөлмөр хамгааллын хэрэгсэлийг тогтмол олгосон.
3	Болзошгүй аваар ослын үед яаралттай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Уурхайн талбайд анхны тусламжийн хайрцагийг байрлуулан, багаж хэрэгсэлийн нөөц хүрэлцээтэй байгаа эсэхэд тогтмол хяналт тавьсан.
4	Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах	Ажилчдад Хөдөлмөр хамгааллын сургалтыг нэг удаа зохион байгуулан, өдөр бүр ажилд гарахын өмнө тухайн өдөр хийгдэх ажлаас хамааруулан хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгсөн.
5	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах. Эрүүл ахуйн сургалт зохион байгуулах	2025 оны 4 сарын 17-ны өдөр 12 ажилтан Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.
6	Мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс ажлын байранд ажилд гарах болгонд сэрэмжлүүлэг өгөх	2025 оны Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төлөвлөгөөний дагуу ажилчдад мэдээлэл олгосон бөгөөд өдөр бүр ААЗааварчилгаатай хамт мэдээллийг тогтмол хүргэсэн.

Ажилчдыг ажлын хувцасаар хангах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу “Жанат” ХХК-ны захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 06 тоод тушаалын хавсралтаар баталсан Нүүрст хотгор 1-р давхрага уурхайн орд газрын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийн нормын дагуу 2025 оны 04 дүгээр сард уурхайн бүх ажилчид зориулалтын ажлын хувцасаар бүрэн хангагдсан (*бүртгэлийн хавсралтаар оруулав*).



Зураг - 10. Ажилчдыг ажлын хувцасаар хангасан байдал

Ажилчдыг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу “Жанат” ХХК-ны захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 06 тоод тушаалын хавсралтаар баталсан Нүүрст хотгор 1-р давхрага уурхайн орд газрын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийн нормын дагуу бээлий, амны маск, хамгаалалтын шил болон ажилчдын эрүүл ахуйн хэрэгцээнд саван болон угаалгын нунтаг олгосон (бүртгэлийн хавсралтаар оруулав).



Зураг 11. Ажилчдад олгож байгаа нэмэлт хувийн хамгаалах хэрэгсэл

Болзошгүй аваар ослын үед яаралттай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу уурхайн талбай дээр яаралтай тусламжийн хэрэгсэлтэй хайрцагийг тогтмол цэнэглэн ажиллаж байна.



Зураг -12. Анхны тусламжийн хайрцаг

Анхны тусламжийн хэрэгсэлийн жагсаалт: 1 удаагийн боолт, ариун хөвөн, шархны наалт, боолт, хайч, спирттэй ариун хөвөн шаариг гэх мэт.

Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах: 2025 оны Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төлөвлөгөөг боловсруулан “Эрчим Баян-Өлгий” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар батлуулсан төлөвлөгөөний дагуу уурхайн ХАБЭА-н инженер болон ерөнхий инженер нар 2025 оны 4 дүгээр сард бүх ажилчдад дараах 10 сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан (сургалтын төлөвлөгөөг хавсралтаар оруулав).

1. Хөдөлмөрийн харилцаа болон ХАБЭА-н тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. МУЗГ-ын 2025 оны 06 сарын 29 өдрийн 269-р тогтоолоор шинэчлэн батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлог”-ыг судлан бүртгэх дүрмийн тухай
4. Ил уурхайн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны тухай
5. Ажилчдад осолд дөхсөн тохиолдлыг мэдээллэх тухай
6. Уурхайн хүнд механизмын операторын мөрдөх аюулгүй ажиллагааны тухай
7. Өргөх, зөөх, тээвэрлэх, өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны тухай
8. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх үеийн аюулгүй ажиллагааны тухай
9. Галын аюулгүй ажиллагааны талаар сургалт ба 2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг бүх ажилчдад таниулах
10. Үйлдвэрийн онцлогт тохирсон үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн үйлчлэл, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх



Зураг -13. Сургалт зохион байгуулж байгаа байдал

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ: Уурхайн нийт 12 ажилчдыг 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үзлэгээр ажилчдыг нарийн шинжилгээнд оруулан, мэргэжлийн эмч нараас зөвлөмж авлаа.

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Хог хаягдлын бүртгэл хөтлөх: - Аюултай хог хаягдал - Энгийн ахуйн - 2догч түүхий эд	Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдалыг ангилан ялгаж зориулалтын хогийн савуудад хаясан. Уурхайн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдал болох 1 ш аккумулятор болон 40л техникийн хаягдал тосыг бүртгэн хадгалсан.
2	Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах	Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдалыг ангилан ялгаж байна.
3	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх	Энгийн хог хаягдалын хураамжийг Бөхмөрөн сумын ЗДТГазарт төлсөн /төлбөрийн баримтыг хавсаргав/
4	Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалж тогтмол хугацаанд ачиж буулгах	Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдалыг ангилан ялгаж энгийн хог хаягдалын Бөхмөрөн сумын хогийн цэгт буулгасан.
5	Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн байгаль хамгаалагчийг цалинжуулах	2019 оноос идэвхитэн байгаль хамгаалагчийг цалинжуулан ажиллуулж байна.

Уурхайн үйл ажиллагаанаас гарсан 10 тн энгийн хог хаягдалыг Бөхмөрөн сумын хогийн цэгт тээвэрлэн буулгасан ба хог хаягдалын төлбөрт 500,000 төгрөгийн төлөөд байна. Манай уурхай нь улиралын чанартай ажилладаг бөгөөд тайлант онд нийт 1 ш аккумулятор, 40 л техникийн хаягдал тос гарсан бөгөөд уурхайн аюултай хог хаягдал хадгалах цэгт хадгалж байна.



Зураг -14. Хог ангилан ялгаж, түр хадгалах цэг

Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн байгаль хамгаалагчийг цалинжуулах:
Бөхмөрөн сумын гудамж талбайн цэцэрлэгжүүлэгч иргэнийг 2021 оноос, төвлөрсөн хогийн цэгийн ажилтан идэвхитэн байгаль хамгаалагчийг 2019 оноос тус тус цалинжуулан ажиллуулж байгаа бөгөөд тайлант онд үргэлжлүүлэн ажиллуулсан.

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1. Агаар		
1	<u>Тоосжилт</u> Нийт тоос, PM10, PM2.5	Төлөвлөгөөний дагуу 7 дугаар сард 3 цэгээс дээж аван шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээр стандартаас давсан тохиолдол байхгүй байна.
2	<u>Агаар бохирдуулагч хий</u> - SO ₂ Хүхэрлэг хий - NO ₂ Азотын давхар исэл	Төлөвлөгөөний дагуу 7 дугаар сард 3 цэгээс дээж аван шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээр стандартаас давсан тохиолдол байхгүй байна.
2. Гадаргын болон гүний ус		
2.1	Химийн шинжилгээ	Уурхайн гүний худгийн уснаас 7 дугаар сард дээж аван химийн ерөнхий шинжилгээ хийлгэсэн.
3. Хөрс		
3.1	Хүнд металл	Төлөвлөгөөний дагуу 3 цэгээс дээж аван агрохимийн үзүүлэлтийг тодорхойлууллаа. Шинжилгээний хариуг доор хүснэгтээр нэгтгэн харуулав.

9.1 Агаарын чанарын шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант онд агаарын чанарыг тодорхойлох зорилгоор 7 дугаар сард 3 цэгээс дээж аван, хүхэрлэг хий SO₂, азотын давхар исэл NO₂, орчны тоосжилтийг тодорхойлох зорилгоор Нийт тоосны хэмжээг Увс аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид тодорхойлууллаа.

№	Үзүүлэлт	нэгж	Кемп	Карьер	Пүү	MNS458 5:2016
			2025.07.21	2025.07.21	2025.07.21	
1	Хүхэрлэг хий-	мг/м ³	0.013	0.014	0.015	0.450
2	Азотын давхар исэл	мг/м ³	0.054	0.060	0.070	0.200
3	Тоос Нийт	мг/м ³	0.007	0.018	0.009	0.500

Шинжилгээний үр дүнг **MNS4585:2016** стандарттай харьцуулахад стандартын хүлцэл хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

9.2 Хөрсний шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант оны 7 дугаар сард 3 цэгээс хөрсний дээж аван, Увс аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид агрохимийн шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний хариууудыг доор хүснэгтэнд нэгтгэн харуулав.

Агрохимийн шинжилгээ					
№	Үзүүлэлт	Дээжний дугаар			
		Кемп	Карьер	Пүү	
1	Орчин - рН	8.30	8.21	8.15	
2	Давсжилт-ЕС	335.0	241.0	410.0	
4	Чийг	0.81	0.65	0.50	

5	Ялзмаг	2.2	5.4	1.9
6	Аммони	36.9	46.6	39.1
7	Нитрат	74.0	12.6	15.5
8	Фосфат	3.3	1.2	0.8
9	Сульфат	1884.4	413.7	914.5

9.3 Гадаргын болон гүний усны шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант онд гүний худгийн уснаас 7 дугаар сард дээж аван химийн ерөнхий шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээний үр дүнг MNS 900:2018 стандарттай харьцуулахад хэвийн байна.

Гүний худаг болон шүүрлийн усны чанарын шинжилгээний дүн					
Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Гүний худаг		Шүүрлийн ус	MNS 900:2018
		2023-09-01	2025-07-21		
Кали (K ⁺) + Натри (Na ⁺)	мг/л	136.6	34.1	69.1	200
Аммони (NH ⁴⁺)		0.2	0.06	3.71	1.5
Кальци (Ca ²⁺)		9.6	87.5	48.5	100
Магни (Mg ²⁺)		50.6	46.9	40.8	30
Хлор, (Cl)	мг/л	27.5	26.3	26.9	350
Сульфат (SO ₄ ²⁻)		365.3	173.5	244.9	500
Нитрит, (NO ₂ ⁻)		0.001	0.001	0.006	1
Нитрат, (NO ₃ ⁻)		1.28	1.61	0.32	50
Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)		351.5	319.7	163.5	-
pH	-	7.74	7.83	7.75	6.5-8.6
Нийт хатуулаг	мг/лмг/л	8.68	8.2	5.8	7
Хуурай үлдэгдэл, TDS		6.4			-
Цахилгаан дамжуулах чанар, EC		1115	1081	769	1000
Фосфат, PO ₄			0.014	0.017	3.5
Төмөр, Fe			0.01	0.53	0.3
Фтор, F			1.18	0.53	0.7-1.5
Цахиур, Si			11.8	10.6	

10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

2025 онд Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн № 1 албан тоотой өгсөн шаардлагын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 11-ны өдөр уурхайн талбайн эргэн тойронд их цэвэрлэгээ зохион байгуулан цэвэрлэсэн хогийн бөхмөрөн сумын хогийн цэгт буулгасан (албан тоотыг хавсралтаар оруулав).



Зураг -15. Цэвэрлэгээ зохион байгуулж буй зураг

Бөхмөрөн сумын засаг даргын 2025 оны 04 дүгээр сарны 11-ны өдрийн № 57 албан тоотын дагуу “Нэг зам” төслийг сэргээх ажлын хүрээнд Бөхмөрөн сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн зааврын дагуу “Шинэ ус”-ны олон салаа замыг хаан нэгдсэн 1 замтай болгосон. Нийт 230м газар хэсэгчлэн замуудыг хаалаа.



Зураг -16. Шинэ усны зам хааж байгаа ажлын зураг

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1	Ус, хог хаягдал, орчны шинжилгээнүүдийн гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай хийж ажиллах.	Хар нуур - Ховд голын сав газрын захиргааны 2025 оны 03 сарын 06-ны Е-2025-000234 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан, Увс аймгийн БОГ-ын дарга 2025 оны 04 сарын 10-ны өдрийн А/12 тоот ус ашиглах зөвшөөрөл олгон, 2025 оны 04 сарын 10-ны өдөр дугаар 01 ус ашиглах гэрээ байгуулсан. Орчны хяналт шинжилгээ хийлгэх гэрээг УЦУОХШТөвтэй 2025.05.22-нд шинэчлэн байгууллаа.
2	Цаг үеийн байдал орон нутагт хүндэрсэн тохиолдолд аймаг, сум, багийн удирдлага иргэдтэй хамтран ажиллах	2025 онд Бөхмөрөн сумын гудамж талбайн цэцэрлэгжүүлэгч иргэн, төвлөрсөн хогийн цэгийн ажилтан идэвхитэн байгаль хамгаалагчийг цалинжууллаа. Мөн Бөхмөрөн сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.
3	Уурхайн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	2025.04.17-нд Баян-Өлгий аймгийн эмнэлэгт 12 ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах	Уурхайн нийт ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн ханган ажилласан.
5	Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал түймрийг унтраах багаж хэрэгсэлийг бэлтгэн байнгын бэлэн байдалд байлгах	Гал түймрийг унтраах багаж хэрэгслийн нөөцийг байнга хянаж бэлэн байлгаж байна
6	Байгаль орчин байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл, аюулгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг жилд 2 удаа тогтмол хийнэ.	2025.04.02-ны өдөр аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулсан
7	Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 1 удаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээллэнэ.	2025 оны 11 дүгээр сард мэдээллэсэн.
8	БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг Увс аймгийн БОГазарт хүргүүлж дүгнүүлэх	2025 оны 11 дүгээр сард хүргүүлсэн.
9	БОУАӨЯ-ХБОБНУГазарт дүгнүүлсэн тайланг дараа оны төлөвлөгөөний хамт хүргүүлэх	Тайлан дүгнүүлсэний дараа 2025 оны 12 дугаар сард хүргүүлнэ.

Ус, хог хаягдал, орчны шинжилгээнүүдийн гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай хийж ажиллах: Хар нуур - Ховд голын сав газрын захиргааны 2025 оны 03 сарын 06-ны Е-2025-000234 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан, Увс аймгийн БОГ-ын дарга 2025 оны 04 сарын 10-ны өдрийн А/12 тоот ус ашиглах зөвшөөрөл олгон, 2025 оны 04 сарын 10-ны өдөр дугаар 01 ус ашиглах гэрээ байгуулсан. Орчны хяналт шинжилгээ хийлгэх гэрээг увс аймгийн УЦУОХШТөвтэй 2025.05.22-нд шинэчлэн байгуулсан.

Цаг үеийн байдал орон нутагт хүндэрсэн тохиолдолд сум, аймгийн ЗДТГтай хамтран ажиллах: Энэ онд цаг үеийн байдал тайван байсан тул сумтай байгуулсан хамтын ажилгааны гэрээний дагуу ажлаа гүйцэтгэсэн болно. Энэхүү ажлын хүрээнд 6 ажил хийж гүйцэтгэсэн бөгөөд байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлыг энэхүү тайланд орууллаа. Үүнд:

1. Бөхмөрөн сумын хогийн цэгт хашаа барьсан.
2. Шинэ усны худаг засварлах (дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 4-р бүлэг БОЯБДХамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт хэсгээс харна уу)
3. 577 өрхөд нүүрс олгосон.
4. 2 хүнийг цалинжуулах (Бөхмөрөн сумын гудамж талбайн цэцэрлэгжүүлэгч иргэнийг 2021 оноос, төвлөрсөн хогийн цэгийн ажилтан идэвхитэн байгаль хамгаалагчийг 2019 оноос тус тус цалинжуулан ажиллуулж байна.)
5. “Ачит нуур дэвэлийн арал”.байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны сургалт, сурталчилгааны самбар хийх зардал өгсөн.

Дээрх 5 ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд Бөхмөрөн сумын Засаг дарга хүлээн авч акт үйлдсэн.



Зураг -17. Бөхмөрөн сумын хогийн цэгт хашаа барих ажлын зураг

Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал түймрийг унтраах багаж хэрэгсэлийг бэлтгэн байнгын бэлэн байдалд байлгах: Уурхайн талбайд гал түймрийн аюул гарсан тохиолдолд хэрэглэгдэх багаж хэрэгсэлийг үргэлж бэлэн байдалд ашиглах зорилгоор 2 цэгт бэлтгэн байршуулсан байгаа. Галын сараанд байрлуулсан багаж хэрэгсэлийг ХАБЭА-н инженер болон аж ахуйн няравын бүрэлдэхүүнтэй комисс 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр тоолон бүрэн байдлыг шалгасаны дараа манаачид хүлээлгэн өгсөн. Уурхайн манаач галын сараанд байрших эд зүйлсын бүрэн байдлыг хариуцан ажиллах бөгөөд ХАБЭА-н инженер давхар хяналт тавин ажиллаж байна. 2 цэгт байрших галын сараанд нийт галын хор 4ш, том хөрөө 2ш, сүх 2ш, хүрз 4ш, галын цохиур презент 4ш, дүнжин (хувин) 5ш болон дэгээ 2ш тус тус байршиж байна.



Зураг -18. Уурхайн талбайд байрлах галын сараа

Байгаль орчин байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл, аюулгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг жилд тогтмол хийнэ: Байгаль орчин, гал түймэр болон байгалийн гамшгийн гэнэтийн аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, компанид мөрдөгдөж буй дүрмийн талаар нийт ажилчдын дунд 4 дүгээр сарын 02-ны өдөр сургалт зохион байгуулсан (*Дэлгэрэнгүй мэдээллийг осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт хэсгээс харна уу*).

Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 1 удаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээллэнэ: Байгаль орчин хамгаалах ажлын тайланг 2025 оны 11 дүгээр сард Бөхмөрөн сумын ЗДТГазарт тайлагнан, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээлэл хийсэн.

БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг Увс аймгийн БОГазарт хүргүүлж дүгнүүлэх:
2025 оны 11 дүгээр сард хүргүүлэв.

БОУАӨЯ-ХБОБНУГазарт дүгнүүлсэн тайланг дараа оны төлөвлөгөөний хамт
хүргүүлэх: Тайлан дүгнүүлсэний дараа 2025 оны 12 дугаар сард хүргүүлнэ.

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

БОМТөлөвлөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа /он, сар /	Зохион байгуулах газар
Бөхмөрөн сумын ЗДТГазар	Хэвлэмэл	Хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг хянуулах	2025.11	Уурхай
Увс аймгийн БОГазар	Хэвлэмэл		2025.11	Уурхай
БОУАӨЯ-ХБОБНУГазар	Хэвлэмэл		2025.11	Уурхай

Хавсралт

Хавсралтын баримтын жагсаалт

1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар
4. Ус ашиглуулах дүгнэлтийн хуулбар
5. Ус ашиглах гэрээний хуулбар
6. Ус цаг уур орчны шинжилгээний төвтэй байгуулсан гэрээний хуулбар
7. “Жанат”ХХК-ийн нүүрст хотгор 1-р давхрага уурхайн 2024 оны 01 сарын 02 өдөр гаргасан дугаар 06 тоот тушаал болон ажилчдад олгосон ажлын хувцас, хэрсэгсэлийн жагсаалт
8. 2025 оны хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтын батлагдсан төлөвлөгөө
9. Хөрсний шинжилгээний дүнгийн хуулбар
10. Агаарын шинжилгээний дүнгийн хуулбар
11. Усны шинжилгээний дүнгийн хуулбар
12. Хяналт шинжилгээний цэгийн байршлын зураг
13. 2025 онд тарьсан модны байршлын зураг



УВС АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
"ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ"
ХУВЬЦААТ КОМПАНИ**

212100, Баян-Өлгий аймаг, Өлгий сум.
5-р баг, Эм-Жи-Эс тауэр, 5н давхар
Утас: 7042-2512, 7533-2525. Факс: 014-222-2512
И-мэйл: erchim_murat@yahoo.com

2025.10.20 № 2/254
танай _____ -ны № _____ -т

Тайлан хянуулах тухай

Эрчим Баян-өлгий ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын ашиглалтын MV-5696А дугаар тусгай зөвшөөрөлтэй "Нүүрст хотгор 1-р давхарга" ил уурхайн төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.1-д заасны дагуу хүргүүлж байна.

Увс аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээр тайланг хянуулж, дүгнэлт гарган баталгаажуулж өгнө үү.

Хавсралтаар дараах бичиг баримтыг хүргүүлэв.

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан - 1 хувь

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ТИЛЕУБЕРДИ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.07.04

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

№ 000075599

0210001004

/ Улсын бүртгэлийн дугаар /

2003821

/ Регистрийн дугаар /

Эрчимбаян өлгий

Хувьцаат компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

1996.03.11

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

3530

/ код /

Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

3510

7490

Цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа

Ашигт малтмал ашиглах

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

263

/ гишүүдийн тоо /

652 000,00

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Баян-Өлгий, Өлгий, 4-р баг, Их булан, 0, Утас1: 22594, Утас2: 0, Факс: 0

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Баян-Өлгий аймгийн улсын
бүртгэлийн хэлтэс

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2015 он 9 сар 30 өдөр

ТТС2503 д. 5216722

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Дакёй овогтой Мурат-а Захирал-р томилсныг бүртгэв.	2006.07.04	А.Бэхболат
2	Дахин гэрчилгээ олгов.	2015.09.30	Б.Сауле УЛСЫН БҮРТГЭГЧ 063
3	Мурат овогтой Тилеуберди -а Захирал-р томилсныг бүртгэв.	2016.09.07	УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ 23/1-08 Р.Бауржан
4	Өөрийн хөрөнгийн хэмжээ 598382.3 мян төг-р хасагдаж нийт 53617.7 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2017.07.28	УЛСЫН БҮРТГЭГЧ 063 Б.Сауле
5	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 263 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.03.02	УЛСЫН БҮРТГЭГЧ 063 Б.Сауле
6	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020-10-16	УЛСЫН БҮРТГЭГЧ 063 ТЕГ

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 5696А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар
зүйлийг үндэслэн

Увс аймаг /хот/-ийн

Бөх.иерен сум /дүүрэг/-ын

Жуурст хотгор нэртэй газарт орших

29 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд

заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 211001067 тоот гэрчилгээтэй

Увсжан, У.Н.Ж -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавералтгүй бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Л. БОЛД

2007 оны 01 сарын 29 өдөр


Улаанбаатар хот



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

MV-005696

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
024-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 21 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.05.01 – 2024.05.01 хүртэл	<div data-bbox="1105 474 1365 569" style="border: 1px solid black; padding: 2px;"><p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС 2023.04.07 ХТ07043</p></div> 
025-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 22 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.05.01 – 2025.05.01 хүртэл	<div data-bbox="1114 1077 1382 1178" style="border: 1px solid black; padding: 2px;"><p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ02404.10</p></div>

XACBANK MENT № 11316-08

ТӨЛБӨРИЙН БАРИМТ TRANSFER OF FUNDS



Салбар IT Branch НАЛАЙХ САЛБАР	Он Year 2025	Сар MM 05	Өдөр DD 07	Мөнгөний нэгж Currency	Бэлэн бусаар Non cash <input checked="" type="checkbox"/> Бэлнээр Cash <input type="checkbox"/>
ХЭНЗЭС FROM	Нэр Customer name АРИУНАА ЧАКИЙ			Төлбөрийн зориулалт Details of payment <i>Б.НСБЖ-ЭРЧИМ / РД-2063824 Батаагаа</i>	
	Дансны дугаар Account No 5000849647				
Дүн Amount <i>7525000.00</i>		Бичгээр In writing долоон сая таван зуун хорин таван мянган төгрөг			
ХЭНД TO	Нэр Customer name БО НӨХӨН СЭРГЭЭХ			Гарын үсэг Signature 1-р 1st <i>Ариунаа</i>	Тамга Stamp
	Банк Beneficiary's bank БАТАЛГАА 90 - ТӨРИЙН САН				
	Дансны дугаар Account No 100900013406			2-р 2nd	
Үйлчилгээний хураамж Service charge 300.00					
Гүйлгээ хийсэн Teller 	Огноо Date 09:56:52			Хянасан Checked by	



УС АШИГЛУУЛАХ ДУГНЭЛТ

2025 оны 3 дугаар
сарын 6 -ний өдөр

Дугаар Е-2502-000234

Улаанбаатар хот
Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Эрчимбаян өлгий ХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 2003821
Захирал: Тилеуберди
Холбоо барих дугаар: 22594
Факс:
И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Нүүрст хотгор 1 дүгээр давхарга уурхай
Байршил: Үвс, Бөхмөрөн, 2-р баг, Хар алтат
Харьяалагдах сав газар: Хар нуур, Ховд голын сав газар
Хамаарах салбар: Үүл уурхай
Төслийн дэлгэрэнгүй: "Эрчимбаян өлгий" ХК-ийн эзэмшиж буй МУ-005695 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Нүүрст-Хотгор 1-р давхаргын уурхай нь 2009 оноос эхлэж үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд хайгуулын ажлыг дахин хийлгэж, ордын нөөцийг шинэчлэн тогтоолгосон. ТЭЗҮ-г боловсруулж, ЭБМЗ-өөр батлуулж, БОНБУ-г хийлгэсэн. 2014 оны 06 сарын 29-ний өдөр улсын комисс тус уурхайд ажиллаж, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосон.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Эрчимбаян өлгий

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
120	2 ээлжээр	30	8	8

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ажуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	15.0	хоногт 1 хун	
Шавхан зайлуулсан усны хэмжээ	3700.0	м3	
Үүрхэйн зам талбайн усалганд шаардлагатай усны хэмжээ	10000.0	м3	
тарилсан мод, Ногоон байгууламж услах	500.0	ш	

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Ундаахуй	1.0	86.4	

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : Шүтээн байгаль ХХК
Холбоо барих : 99222100
Нэмэлт мэдээлэл :

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
